



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/02

Чингис хот

Г М.Урандолгиод сахилгын шийтгэл Г
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.4, 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.1, 26.3 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам”-ын 3, 4, 5-ын “а”, 6, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам”-ын 9.1, 10.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод гадаад харилцаа, шагнал ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Урандолгио нь 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан аймгийн 2017 оны шилдэгүүд шалгаруулах арга хэмжээнд дарааллын алдаа гаргасан тул сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг М.Урандолгиод үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ГАНБААТАР